



Зөвлөмжийн Цуврал

АС140-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (0)

**Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний
байгууллагын гэрчилгээжүүлэлт**

2016 оны 4 сарын 27

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг. Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд мөн зохих АС-д нэмж оруулна.

Энэхүү АС-д 140.15 гэх мэт дугаарласан заалт бүр нь ИНД-140-ийн холбогдох заалтын ишлэл юм.

Зорилго

ИНД-140-ийн нийцлийг харуулах зорилгоор Даргын хүлээн зөвшөөрөхүйц аргачлалыг энэ АС-д заасан.

Чиглэл

Энэ баримт бичиг нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нар болон гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийг дэмжихэд чиглэсэн.

Холбогдох дүрмүүд

Энэхүү АС нь ИНД-140-тэй хамааралтай.

Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-140-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

АС140-1-ийг NZ АС140-1-ийн 1999 оны 1 сарын 12-ны өөрчлөлт 0-д үндэслэн боловсруулсан.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл.....	3
140.3. Нэр томъёо болон товчлол.....	3
140.5. Гэрчилгээний шаардлага.....	3
В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага.....	4
140.51. Ажилтанд тавих шаардлага	4
ХАВСРАЛТ А - Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт	6
Нэмэлт мэдээлэл.....	6
А.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах	6
А.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хамгаалалтын хяналт.....	6
А.3. Агаарын хөлгийн шалгалт	6
А.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон төхөөрөмж	7
А.5. Хүнд аюулгүйн үзлэг хийх.....	9
А.6. Рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийх	9
А.7. Гар тээшийг гараар шалгах	10
А.8. Хураан авсан эд зүйлийн талаар авах арга хэмжээ	10
А.9. Аюулгүйн үзлэг хийж байгаа этгээдэд тавих хяналт	11
А.10. Аюулгүйн үзлэгийн зөрчил	11
А.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө болон дохио.....	11
А.12. Хөдөлгөөнт эргүүл	12
А.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүйн хамгаалалт	13
А.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг	13
А.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж бататгах.....	13
А.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдах үйлчилгээ.....	14
А.17. Явган эргүүл	14
А.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт	14
А.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл.....	15
А.20. Нууцлал болон мэдээлэл	15
А.21. Бусад байгууллагатай харилцах	16
А.22. НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага	16
А.24. Давтан сорилт хийх.....	17

А Бүлэг - Ерөнхий зүйл

140.3. Нэр томьёо болон товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт орсон.

140.5. Гэрчилгээний шаардлага

ИНД-140 нь аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацгийн байгууламжид нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй байгууллага болон ИНЕГ-ын Даргын байгуулсан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний албыг энэ Дүрмийн дагуу гэрчилгээжсэн байх шаардлагатай.

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагад хамааралтай дүрмийн бүх заалт болон тэдгээр байгууллагад тавих шаардлага нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний албанд мөн хамааралтай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

140.51. Ажилтанд тавих шаардлага

Тухайн байгууллагын Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтныг томилсон байх шаардлагатай ба энэхүү этгээд нь тус байгууллагын гэрчилгээжсэн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай бүхий л нөөцийг бэлэн байлгах мөн Ерөнхий зааварт заасан журмын хэрэгжилтийг бататгах санхүүгийн болон удирдлагын бүх эрх мэдэлтэй байна.

Ерөнхий зааварт заасан удирдах ажилтнууд нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой. Эдгээр удирдах ажилтнууд тухайн ажлын байранд ажиллахад тохирсон мэргэжилтэй байх шаардлагатай бөгөөд Ерөнхий зааварт заасан бүх үйлчилгээ болон байгууламжийн хангалт, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг хариуцдаг байх үүрэгтэй. Тухайлбал:

- (a) Чикагогийн Конвенцийн Хавсралт 17-д заасны дагуу тухайн аэродром дээр олон улсын иргэний нисэхийг хууль бус үйлдлээс хамгаалах, шаардлага хангасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг боловсруулж бататгана.
- (b) Байгууллагын гэрчилгээжсэн ИНД-140-д заасан бүхий л ажил, үүрэг хангалттай хэрэгжиж байгааг бататгах үүрэг хүлээнэ.

Ахлах ажилтнууд нь НАХ-ын ажилтнуудын шуурхай ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй бөгөөд тухайн нэгжийн захиргааны болон ажилтны ажил үүргийг гүйцэтгэнэ. Тухайлбал, захиргааны, аюулгүйн хамгаалалтын болон аюулгүй байдлын бүх ажил үүргүүдийг байгууллагын Ерөнхий зааварт заасан стандартын дагуу зөв хийж байгааг бататгах зорилгоор туслах ажилтнуудын ажлыг шалгаж, хяналт тавьж ажиллана.

Мөн ахлах ажилтан нь өөрийн удирдлагад хамаарах бүх НАХ-ын ажилтан нарт хяналт тавьж ажиллах үүрэгтэй бөгөөд нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой өдөр тутмын үйл ажиллагаа болон онцгой нөхцөлийн аливаа асуудалд арга хэмжээ авч ажиллана. Ялангуяа, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндсэн үүргийг цаг тутам гүйцэтгэхэд хангалттай боловсон хүчин ажиллаж байгааг, мөн ИНД-140-д нийцүүлэн өгсөн үүрэг, даалгаврыг хамгийн үр дүнтэй, тохиромжтой хэлбэрээр ажилтнуудын өдөр тутмын ажил үүргийг зохицуулж бататгаж ажиллана.

Байгууллагын Ерөнхий зааварт заасан үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх хангалттай тооны НАХ-ын ажилтантай байна.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь дээрх хариуцлагын бүсүүдэд бүхэлд нь, эсхүл хамтатган тухайн ажилтнуудыг томилон ажиллуулж болох боловч тэдэнд шилжих хариуцлагыг тодорхой болгох үүрэгтэй. Ингэхдээ ямар ч тохиолдолд тэдгээр ажилтнууд Гүйцэтгэх захирлын өмнө хариуцлага хүлээдэг байх үүрэгтэй.

Тухайн ажил үүрэгт томилохоор нэр дэвшүүлсэн этгээдийг САА 24140/01 маягтаар тодорхойлж, холбогдох ажил үүргийг тодорхойлж хүсэлтэд хавсаргана. Ажлын байр, хүлээх үүрэг, хариуцлагатай нь холбоотой мэдлэгийн түвшин, хангалттай дадлага, туршлага нь тухайн этгээдийг хүлээн зөвшөөрөх үндэслэл болно.

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага (НАХҮБ) нь шинээр ажилд орохоор зорьж байгаа боловсон хүчинд мэргэшлийн өмнөх стандартыг тогтоосон байх шаардлагатай. Суралцагч аливаа сургалтыг амжилттай төгсөх боломжтой хэмжээнд стандартыг тогтоох ба ажлын байранд гүйцэтгэх үүргийг биелүүлэхэд тохирсон болон эрүүл мэндийн хувьд шаардлага хангасан байна.

Байгууллагын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулах нь тэдгээрийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхэд ашиг тустай болохыг зөвлөж байна.

ХАВСРАЛТ А - Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

Нэмэлт мэдээлэл

ICAO Иргэний нисэхийг хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүйн хамгаалалтын Заавар (Security Manual for Safeguarding Civil Aviation Against Acts of Unlawful Interference (Doc. 8973-Restricted))-т нарийвчилсан зөвлөмж болон журмууд тусгагдсан байдаг тул НАХҮБ нь тэдгээрийг шууд хэрэгжүүлж болно.

Монгол Улсын Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөр нь энэ Дүрмийн шаардлагад илүү хүч нэмдэг бөгөөд энэ Дүрмээр шаардсан баримт бичгийн журамд дэмжлэг болно.

А.1. Үзлэгийн дараах бүсийг шалгах

Үзлэгийн дараах бүсийг шалгах зорилго нь үзлэгээр орсон этгээд үзлэгийн дараах бүсэд нуусан, зөвшөөрөгдөөгүй эд зүйлд хүрээгүй гэдгийг бататгах зорилгоор аюулгүйн үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх хэсгийг бүхэлд нь шалгаж зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэхэд оршино.

Үзлэгийн дараах бүсийн шалгалтыг тухайн бүсэд орхисон, эсхүл нуусан зөвшөөрөгдөөгүй эд зүйл байхгүй гэдгийг бататгах зорилгоор хийх үүрэгтэй. Үзлэгийн дараах бүсийг хэзээ ч шалгаж болохоос гадна зорчигчийн аюулгүйн үзлэг эхлэхийн өмнө заавал шалгасан байна.

А.2. Үзлэгийн дараах бүсийн аюулгүйн хамгаалалтын хяналт

Аюулгүйн үзлэгийн цэгийн дараах бүсэд байрлах үйлчилгээний цэгт худалдааны тусгай зохицуулалт хийгээгүй бол агаарын хөлгийн бүхээгт авч орохыг хориглосон эд зүйл худалдаалах, ханган нийлүүлэхийг хориглоно.

Олон улсын арилжааны агаарын тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа агаарын тээвэрлэгч нь зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг тухайн агаарын хөлөгт тээвэрлээгүй, эсхүл аюулгүйн үзлэгийн дараа аливаа этгээдэд дамжуулаагүй болохыг бататгах зорилгоор агаарын хөлөгт байгаа бүх зорчигчийг аюулгүйн үзлэгт заавал хамруулсан байхаас бусад тохиолдолд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

Үзлэгийн дараах хүмүүст хяналт тавих нь зөвшөөрөгдөөгүй эд зүйлд хүрээгүй болохыг бататгах зорилготой.

Энэхүү зорилгоор НАХ-ын ажилтнуудыг ээлжийн хуваариар гаргаж хяналт тавих үүрэг гүйцэтгэнэ.

А.3. Агаарын хөлгийн шалгалт

Олон улсын арилжааны агаарын тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрөгдсөн төхөөрөмжөөс бусад зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг орхисон, эсхүл байрлуулаагүй болохыг бататгах зорилгоор агаарын хөлгийг шалгаснаас бусад тохиолдолд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

Нислэгт гаргахаар бэлтгэгдэж байгаа агаарын хөлгийг ямар нэг шалтгаанаар “өндөр эрсдэлтэй” гэж тооцон, НАХ-ын ажилтан агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн техникийн ажилтнуудын тусламжтайгаар бүрэн хэмжээний хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Шалгалтыг тухайн агаарын хөлгийн шалгах хуудсыг ашиглан тогтмол хийж гүйцэтгэнэ. Энэхүү шалгалт нь агаарын хөлгийн бүхээгт орхисон, эсхүл байрлуулсан байж болзошгүй зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэх хангалттай хүчин чармайлт юм.

Тухайн агаарын хөлгийг өндөр эрсдэлтэй нислэг гэж тодорхойлоогүй, олон улсын аюулгүйн хамгаалалтын журмаар ердийн нислэг гэж үзсэн хэвийн нөхцөлд ИНД-108-д шаардсаны дагуу нисэх багийн нислэгийн бүхээгийг шалгасан тохиолдолд шалгалтыг хангалттай гэж үзнэ. Засвар, эсхүл бусад техник үйлчилгээнд орж байх үедээ аюулгүйн хамгаалалттай орчинд байгаа агаарын хөлөгт энэ шаардлага мөн үйлчилнэ.

НАХ-ын ажилтнаас агаарын хөлгийг шалгахыг шаардсан тохиолдолд, шалгалтыг агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл нуусан, эсхүл авч ороогүй гэдгийг бататгах хэлбэрээр гүйцэтгэнэ. Шалгалтыг сургуультай нохой, цахилгаан, эсхүл механик арга хэрэгслийн тусламжтай хийж гүйцэтгэнэ.

Энгийн, эсхүл хуваарьт шалгалтад нислэгийн бүхээг, суудлын дээрх тээшний тасалгаа, шалны талбай, бие засах газар, суудал хоорондын зай болон өмнөх нислэгийн үед зорчигчийн нэвтэрсэн байж болох бусад хэсгийг хамруулан шалгана. Шалгалт нь агаарын хөлгийн дээр дурдсан хэсэгт орхисон, байрлуулсан байж болох зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэх хангалттай хүчин чармайлт байх ёстой.

НАХ-ын ажилтан, өмнө нь аюулгүйн үзлэг хийлгэлгүй үйлчилгээнд орсон агаарын хөлгийн бүхээгт төлөвлөсний дагуу тогтсон аргаар шалгалт хийх үүрэгтэй. Ингэхдээ тэд бүхээгт орхисон, эсхүл нуусан байж болзошгүй зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг олохын тулд өмнөх нислэгийн зорчигчид, эсхүл бусад хүмүүс нэвтрэх боломжтой бүх газарт бүхэлд нь шалгалт хийгдсэн эсэхийг баталгаажуулна.

А.4. Аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон төхөөрөмж

Үзлэгээр ороогүй этгээд аюулгүйн үзлэгийн цэгээр нэвтрэхээс сэргийлэх аюулгүйн хамгаалалтын бүхий л арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Нийтийн эзэмшлийн бүсээс үзлэгийн дараах бүсэд нэвтрэх этгээд заавал аюулгүйн үзлэгээр орсон байхаар аюулгүйн үзлэгийн цэгийг байрлуулсан байна.

Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь аюулгүйн үзлэгийг тухайн агаарын хөлгийн явах нислэгийг шаардлагагүй саатуулахгүй байхаар, үзлэгийн стандартыг хангасан хурдтайгаар гүйцэтгэх хангалттай тооны ажилтан болон төхөөрөмжтэй байхыг бататгах ёстой. Агаарын хөлгийн бүхээгт тээвэрлэх боломжтой, овор ихтэй эд зүйлийг бүртгэгдсэн тээш хэлбэрээр тээвэрлүүлэхээр холбогдох агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн байна.

Тухайн байгууллага газар дээр нь үзлэг хийх болон төхөөрөмж, материал, байгууламжид сорилт хийх журамтай байх ёстой. Төхөөрөмж, материал, байгууламжийг ашиглахын өмнө үйлдвэрлэгчийн стандартад нийцсэн ажиллагаатай байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна.

Рентген үзлэгийн төхөөрөмж нь стандарт step-wedge системийн 5 дахь алхмаар 0.51 мм (24-gauge) хэмжээтэй утас илрүүлэх чадвартай байх ёстой. Тухайн төхөөрөмжийн цацрагийн хэмжээ нь аюулгүй байдлын хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой ба хэрэв түүнээс хэтэрсэн бол автоматаар унтардаг байх ёстой.

Төхөөрөмжид ямар нэгэн гэмтэл гарсан тохиолдолд техникийн ажилтан шалгаж, аюулгүйн үзлэгийн үйл ажиллагаанд дахин ашиглахаас өмнө ажиллагаатай гэдгийг баталгаажуулна.

Стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэгийн төхөөрөмжид сорилт хийх болон хэмжилт хийхэд ашиглах ёстой. Стандарт сорилын биет тохирч байгааг тогтмол хугацаанд шалгаж байх шаардлагатай. Сорилын биет нь тухайн төхөөрөмж бүх зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг илрүүлэхээр тохируулагдсан болохыг бататгах нягтрал болон хэмжээтэй байх ёстой.

Рентген төхөөрөмж болон металл илрүүлэгч төхөөрөмжийг анх суурилуулж ажиллуулах этгээд нь мэргэшсэн, тэдгээрийг ашиглах чадвартай байх үүрэгтэй. Төхөөрөмжийн бүрдэл хэсэг бүрийн үзүүлэлтийг бататгахаар тухайн төхөөрөмжийг тохируулж, шалгах ёстой. Сорилт нь төхөөрөмжийг өөрт нь дагалдаж ирсэн үйлдвэрлэгчийн ашиглалтын зааварт заасан техникийн тодорхойлолтын дагуу ажиллаж байгаа болохыг бататгах зорилготой.

Тухайн байгууллагад бүх төхөөрөмж, материалыг аюулгүй ашиглахад нь зориулж ажилтнуудад тохируулга, үзлэг, сорилын тохирох төхөөрөмж бэлэн байгаа эсэхийг бататгах шаардлага тавьдаг.

Шинэ төхөөрөмж суурилуулах үед хөтөлсөн бүртгэлд суурилуулалтын болон хийгдсэн бүх шалгалтуудыг үр дүнтэй нь хамт бүртгэсэн байна. Бүртгэл нь тухайн төхөөрөмж зөв ажиллаж байгааг илтгэн харуулна.

Нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчил гарсан тохиолдолд тухайн байгууллага өмнөх нислэгийн аюулгүйн үзлэгт ашиглагдаж байсан байж болох, эсхүл үзлэгтэй холбоотой төхөөрөмж болон байгууламжид сорилт хийнэ. Агаарын хөлгийн бүхээгт хууль бусаар нэвтэрсэн аюулгүйн үзлэгээр орсон этгээдээс илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйл, эсхүл нислэг дуусгавар болоход зорчигчоос илэрсэн зөвшөөрөгдөөгүй эд зүйлтэй ижил эд зүйлд сорилт хийнэ. Энэ тохиолдолд дээрх зөрчил гарсан даруйд үзлэгийн төхөөрөмжид сорилт хийж, үзлэгийн төхөөрөмж гэмтэлтэй байсан эсэхийг тогтооно. Үүнээс гадна, аюулгүйн хамгаалалтын зөрчилтэй холбоотой байж болох үзлэгийн дараах бүсийн шалгалт, аюулгүйн үзлэгийн цэгийн хамгаалалт болон агаарын хөлгийн шалгалтын журмуудын нэгдмэл/бодит байдлыг шалгах сорилт хийнэ.

А.5. Хүнд аюулгүйн үзлэг хийх

Хүний биед хийх аюулгүйн үзлэг нь агаарын хөлөгт зөвшөөрөгдөөгүй эд зүйл авч орохоос сэргийлэх зорилготой.

Тухайн этгээд аюулгүйн үзлэгээс чөлөөлөгдсөн, эсхүл үзлэгт орохоос татгалзсанаас бусад тохиолдолд үзлэгийн дараах бүсэд орох тэргэнцэртэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтаасан олон улсын нислэгийн бүх зорчигчдыг НАХ-ын ажилтан аюулгүйн үзлэгт хамруулсан байна.

Аюулгүйн үзлэгийг гараар, эсхүл төхөөрөмжөөр, эсхүл тэдгээрийг хослуулан гүйцэтгэнэ.

Энэхүү бодлого нь ямар нэг шалтгаанаар Дарга тухайн нислэгийн зорчигчдод аюулгүйн үзлэг хийхийг шаардсан тохиолдолд, аливаа бусад нислэгт хамаарна.

НАХ-ын ажилтан аливаа хүнд үзлэг хийхдээ тухайн этгээдийн эзэмшилд зөвшөөрөгдөөгүй эд зүйл байхгүй гэдгийг баттай нотлох хүртэл үзлэгийг гүйцэтгэсэн байна.

А.6. Рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийх

Рентген төхөөрөмжөөр тээшинд хийх аюулгүйн үзлэгийн зорилго нь зөвшөөрөгдөөгүй эд зүйл агаарын хөлгийн бүхээгт авч орохоос сэргийлэх юм.

Олон улсын арилжааны агаарын тээврийн зорчигч үйлчилгээ эрхэлж байгаа агаарын тээвэрлэгч нь зөвшөөрөгдөөгүй эд зүйл тээшинд байхгүй болохыг бататгах зорилгоор бүх зорчигчийн авч яваа гар тээшинд гараар, эсхүл рентген төхөөрөмжөөр аюулгүйн үзлэг хийснээс бусад тохиолдолд нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй. Энэ нь тухайн нислэгийн гар тээшинд аюулгүйн үзлэг хийх хүсэлт Даргаас гаргасан бусад нислэгүүдэд хамаарна.

НАХ-ын ажилтан эд зүйлд гараар шалгалт хийхдээ тухайн эд зүйлд зөвшөөрөгдөөгүй эд зүйл агуулагдаагүй гэдэгт итгэлтэй байгаагаа бататгана. Гар тээшийг системтэйгээр шалгана. Тээшнээс ямар нэг эд зүйлийг гаргаж тавихаасаа өмнө сайтар шалгасны дараа дараагийн эд зүйлийг шалгаж гаргана. Тухайн эд зүйлийг баглаж боосон, эсхүл лацадсан тохиолдолд өөр бусад аргаар бүрэн шалгаснаас бусад тохиолдолд задалж шалгах ёстой.

Аюулгүйн үзлэгийн ажилтан дараах зүйлийг байнга анхаарах шаардлагатай:

- (a) гар тээш болон бусад авч яваа эд зүйл хэвийн бус хүнд байгааг;
- (b) гар тээш, эсхүл агуулж буй саванд хуурамч, эсхүл нэмэлт ёроол байрлуулсан эсэхийг;
- (c) зэвсэг, эсхүл тэсрэх бодис нууж болох компьютер, тооны машин, зургийн аппарат болон ижил төрлийн хэрэгсэл;
- (d) нэгээс дээш зөвшөөрөгдөөгүй эд зүйл, эсхүл
- (e) зэвсэг болон зэвсгийн төрлийн хэрэгслийг бүрэлдэхүүнээс нь задалж хийсэн хэсгүүд.
- (f) дэлгэц дээр гарсан эд зүйл бүрийг таньж тодорхойлох шаардлагагүй боловч тухайн харагдсан эд зүйл нь аюул учруулж болох эд зүйл биш гэдгийг тодорхойлох шаардлагатай.

Тухайн эд зүйл нь аюултай эд зүйл агуулаагүй болохыг рентген төхөөрөмжөөр зөв тогтоож болохгүй байгаа, эсхүл ямар нэг эргэлзээ байгаа бол цүнхийг онгойлгож, доторх эд зүйлийг гараар шалгана. Өндөр нягтралтай рентген төхөөрөмжөөс бусад төхөөрөмж ашиглаж байгаа үед биетээр шалгах эд зүйлийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй.

А.7. Гар тээшийг гараар шалгах

Компьютер ба түүнтэй ижил төрлийн эд зүйлийн талаарх аюулгүйн хамгаалалтын зөвшөөрөл - Хэдийгээр рентген төхөөрөмжөөр шалгах нь төхөөрөмжийн төрөлд хор хөнөөл учруулахгүй ч, зорчигч үүнийг хүлээн зөвшөөрөхгүй рентген төхөөрөмжөөр шалгуулахаас татгалзаж болох юм.

Лаптоп гэх мэт бага оврын зөөврийн компьютер болон түүнтэй адилтгах электрон хэрэгсэлд биет үзлэг хийж шалгаснаар аюулгүйн хамгаалалт хангагдсан гэж үзэхэд бэрхшээлтэй байдаг.

Иймд эдгээр төрлийн хэрэгслийг гараар болон рентген төхөөрөмжийг хослуулан шалгахад дараах шаардлагыг удирдамж болгоно:

- (a) Агаарын хөлгийн бүхээгт зөвхөн НАХ-ын ажилтан хангалттай шалгаж, тээвэрлэхийг зөвшөөрсөн эд зүйлийг оруулна. Тэсрэх хэрэгсэл болон зэвсгийг электрон хэрэгсэлд нуун авч орохыг завдаж болзошгүй тул энэ төрлийн бүтээгдэхүүнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болохыг үргэлж санах хэрэгтэй.
- (b) Гараар, эсхүл рентген төхөөрөмжөөр шалгасан эд зүйлд аюулгүйн хамгаалалтын хувьд хангалттай гэсэн зөвшөөрөл өгч болмооргүй, ямар нэгэн эргэлзээ байгаа тохиолдолд аюулгүйн үзлэгийн цэгээр нэвтрүүлж болохгүй.
- (c) Компьютер, видео камерын бүрэлдэхүүн хэсэг болон ижил төстэй эд зүйлд биет үзлэг хийж аюулгүйн хамгаалалтын шаардлага хангасан гэсэн зөвшөөрөл олгоход хүндрэлтэй тохиолдолд рентген төхөөрөмжийн тусламжтайгаар шалгана.
- (d) Дээрх эд зүйлийг зорчигч рентген төхөөрөмжөөр шалгуулахаас татгалзсан тохиолдолд НАХ-ын ажилтан гараар шалгах ба зорчигчоос ажиллуулж үзүүлэхийг хүсч болно.

А.8. Хураан авсан эд зүйлийн талаар авах арга хэмжээ

Хураан авсан эд зүйлийг дараах гурван ангилалд хуваана:

- (a) Монгол Улсын Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгөх ИНД-140-д заасан агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй эд зүйл;
- (b) ИНД-92-ын дагуу агаарын хөлгийн бүхээгт тээвэрлэхийг хориглосон аюултай бараа;
- (c) Агаарын хөлгийн бүхээгт тээвэрлэхэд аюулгүйн хамгаалалтын эрсдэлтэй боловч бүртгэлтэй тээшээр авч явах боломжтой, тухайн зорчигчид аялал дууссаны дараа хүлээлгэн өгөх эд зүйл.

Зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг хураан авсан НАХ-ын ажилтнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангах асуудлыг мөн хариуцна. Онцгой нөхцөлийн арга хэмжээ авах хүртэл зэвсгийг рентген төхөөрөмжид байлгана. Аливаа этгээдээс зэвсэг илэрсэн тохиолдолд боломжтой бол саатуулж, тухайн этгээд зэвсэг хэрэглэхээс сэргийлэх арга хэмжээг авна. Зэвсгийг зөрчил гаргасан этгээдийн хамт цагдаагийн байгууллагад хүлээлгэж өгнө.

Аль нэг цэгээс дараагийн нислэгт дамжин суух завсрын аяллын үед тухайн зорчигчид онцгой анхаарал тавьж зохих баримт бичгийн дагуу ажиллана.

А.9. Аюулгүйн үзлэг хийж байгаа этгээдэд тавих хяналт

Аюулгүйн үзлэгт хамрагдсан хүмүүст тавих хяналтын зорилго нь гаднах байдал, эсхүл биеэ авч яваа зан төрх нь аюулгүйн хамгаалалтын өндөр эрсдэл учруулж болзошгүй байдлыг зааж байгаа этгээдийг таньж тогтоох, мөн тухайн этгээд зөвшөөрөгдөөгүй эд зүйл биедээ авч яваагүй гэдгийг бататгахад оршино.

Аюулгүйн үзлэгт хамрагдсан хүмүүст хяналт тавьж сэжигтэй үйлдэл гаргаж байгаа этгээдийг илрүүлэх нь маш чухал. Тухайн зорчигч болон гар тээшинд улам эрчимжүүлсэн нарийвчлалтай үзлэгийг хийх хэрэгтэй. Энэ тохиолдолд тухайн зорчигчийн авч яваа тээшний байршлыг тогтоох, эрж олох арга хэмжээг авна.

Үзлэгт хамрагдсан зорчигч үзлэг хийлгээгүй хүнтэй уулзах, түүнд зөвшөөрөгдөөгүй эд зүйл дамжуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийт зорчигчдод аюулгүйн үзлэг хийлгэснээс эхлээд агаарын хөлөгт суух хүртэл хяналт тавина.

А.10. Аюулгүйн үзлэгийн зөрчил

Аюулгүйн үзлэгийн үйл ажиллагааны нэгдмэл байдал зөрчигдсөн сэжиглэл бий болсон тохиолдолд төлөвлөсөн арга хэмжээг авч ажиллах нь нөөц төлөвлөгөөний зорилго.

Аюулгүйн үзлэгийн хамгаалалтын нэгдмэл байдал зөрчигдсөн нөхцөл байдалд хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөг урьдаас боловсруулж бэлтгэн НАХ-ын ажилтнуудад хүргүүлсэн байна.

Аюулгүйн үзлэг хийгдсэн зорчигчид аюулгүйн үзлэгийн дараа үзлэг хийгдээгүй хүмүүстэй холилдсон, эсхүл ямар нэг байдлаар харьцсан бол үзлэгийн дараах бүсэд зөвшөөрөгдөөгүй эд зүйл үлдээгүй болохыг бататгах зорилгоор аюулгүйн үзлэгийн цэгээс цаана байгаа бүх хүмүүсийг давтан шалгалтад хамруулах, тухайн бүсийг дахин шалгаж бататгахыг нөөц төлөвлөгөөнд тусгасан байна.

Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд илэрвэл аюулгүйн үзлэг хийгдсэн болон хийгдээгүй хүмүүс холилдоогүй байсан ч, энэ нь тухайн эрсдэлтэй бүсэд шалгалт хийх хангалттай нөхцөл болно.

А.11. Аюулгүйн үзлэгийн цэгийн онцгой нөхцөлийн арга хэмжээний төлөвлөгөө болон дохио

Онцгой нөхцөлийн төлөвлөгөө болон дохионы зорилго нь аюулгүйн үзлэгийн цэгт онцгой нөхцөл үүссэн тохиолдолд тохирох арга хэмжээг авахад оршино.

Аюулгүйн үзлэгийн цэгт гарсан зөрчлийн үед хэрэгжүүлэх онцгой нөхцөлийн төлөвлөгөө нь зорчигч, нисэх баг, газрын ажилтан, олон нийт болон хүчний байгууллагын ажилтнуудын аюулгүй байдлыг бататгах ёстой.

Төлөвлөлтөд зэвсэгт халдлага, эсхүл бөмбөг тэсрэх үед авах арга хэмжээг багтаана.

Аюулгүйн үзлэгийн цэгт аливаа ноцтой зөрчил үүсэхэд зорчигчийн урсгалыг зогсоож, хэрэв боломжтой бол тус бүсийг чөлөөлөхөд туслах арга хэмжээг авна.

Нууц дохио тухайн нисэх буудлын цагдаагийн хэсэг, мөн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн онцгой нөхцөлийн хяналтын өрөөнд (хэрэв хамааралтай бол) дуугарахад аюулгүйн хамгаалалтын бүрэлдэхүүн аюулгүйн үзлэгийн цэгт бэлэн байна.

Рентген төхөөрөмжийн дэлгэцэд зэвсэг, эсхүл сэжигтэй хэрэгсэл танигдсан бол зорчигчийг сэжигтэй эд зүйлээс тусгаарлах журмыг төлөвлөгөөнд тусгасан байна.

Зэвсгийг цагдаагийн байгууллага дэмжлэг үзүүлэх хүртэл рентген төхөөрөмжийн дотор хөдөлгөөнгүй байлгана.

Аюулгүйн үзлэгийн цэгт аливаа этгээд зэвсэг хэрэглэх, эсхүл үзлэгийн цэгт хүрэхээс өмнө зэвсэглэсэн этгээд байж болзошгүй нөхцөл бий болсон үед ажилтнууд болон зорчигчид гэмтэл авах, амь насаа алдах эрсдэлээс сэргийлж тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.

Түүнчлэн, сэжигтэй тэсрэх хэрэгсэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээг багтаасан байна.

A.12. Хөдөлгөөнт эргүүл

Аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл түүнтэй адилтгах газар зөрчил гаргагчийг илрүүлэх, барьж саатуулах болон аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах зорилгоор хөдөлгөөнт эргүүл хийнэ.

Аюулгүйн хамгаалалтад заналхийлж болох этгээдийг илрүүлж барих болон периметрийн гадна байрлах хамгаалалттай агаарын навигацийн байгууламжийг багтаасан аюулгүйн хамгаалалттай бүсэд болон түүнтэй адилтгах газар аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах хөдөлгөөнт эргүүлийг 24 цагийн турш хийдэг байх ёстой.

Периметрийн үзлэг - Тухайн аэродромын аюулгүйн хамгаалалттай бүсийн хилийг бүрдүүлж байгаа хамгаалалтын хашаа, хаалт, барилга, байгууламжийн аюулгүйн хамгаалалтыг хангаж, зөвшөөрөлгүй нэвтрэлтийг илрүүлэх болон зөвшөөрөлгүй нэвтрэлттэй холбоотой зөрчил, эсхүл сэжигтэй зөрчилд хариу арга хэмжээ авах зорилгоор тогтмол бус давтамжтай периметрийн үзлэг хийх.

Ачааны / тээвэрлэлтийн талбай - Ачааны болон тээвэрлэлтийн талбайд хийх хөдөлгөөнт эргүүлийн зорилго нь тухайн бүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэгтэй үйл ажиллагаа эрхлэгчид дэмжлэг үзүүлэхэд оршино.

Агаарын навигацийн төхөөрөмж - Агаарын навигацийн байгууламжид хөдөлгөөнт эргүүл хийх зорилго нь тухайн байгууламжид хууль бус үйлдэл гарах эрсдлийг багасгах болон тухайн байгууламжид ажиллаж байгаа хүмүүсийг аюулгүйн хамгаалалтаар хангахад оршино.

Аюулгүйн хамгаалалттай агаарын навигацийн байгууламж гэж Даргын тогтоосон агаарын навигацийн байгууламжид хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

A.13. Шалган нэвтрүүлэх цэгийн аюулгүйн хамгаалалт

Нэвтрэх хяналтын зорилго - Хяналттай нэвтрэх цэгээр зөвхөн зөвшөөрөлтэй этгээд, тээврийн хэрэгсэл, эсхүл онгоцонд суух зорчигчид аюулгүйн хамгаалалттай, эсхүл үйл ажиллагааны бүс рүү нэвтэрч байгаад хяналт тавьж баталгаажуулна.

Нэвтрэх хяналтын цэгүүдэд зөвхөн зөвшөөрөлтэй этгээд тухайн цэгээр нэвтрэхийг зөвшөөрнө гэсэн тэмдэг, эсхүл анхааруулах тэмдэгтүүд байна. Зөрчлийн тухай Хуулийн 14.8.5-д заасны дагуу зөрчил гаргасан этгээдэд торгуулийн шийтгэл ногдуулах мэдээлэлтэй тэмдгийг ил байрлуулсан байна.

Аюулгүйн хамгаалалтын удирдлагын холбогдох нэгж болон цагдаагийн байгууллагын яаралтай хариу арга хэмжээг авах зорилгоор харилцаа холбооны системээр хангасан байна.

Аливаа хяналтын цэг дээр үүрэг гүйцэтгэж байгаа НАХ-ын ажилтан тухайн цэгээр хүчинтэй нэвтрэх үнэмлэх болон баримт бичигтэй этгээд, тийзтэй зорчигч болон зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл аюулгүйн хамгаалалттай, эсхүл үйл ажиллагааны бүс рүү нэвтэрч байгааг бататгана.

A.14. Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг

Аюулгүйн хамгаалалттай бүсэд тээврийн хэрэгсэл болон хүмүүсийг сонгон шалгах нь зөвшөөрөлгүй нэвтэрч болзошгүй тээврийн хэрэгсэл, эсхүл этгээдийг илрүүлэх, шаардлагатай баримт бичиг, зөвшөөрөлгүйгээр нэвтрэх үйлдлийг таслан зогсоож саатуулах зорилготой юм.

НАХ-ын ажилтан аюулгүйн хамгаалалттай, эсхүл үйл ажиллагааны бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхийг завдсан хүн болон тээврийн хэрэгслийг таньж тодорхойлох, зөвшөөрөлгүй нэвтрэх хууль бусад үйлдлийг таслан зогсоохын тулд хүн ба тээврийн хэрэгслийг сонгон шалгана.

A.15. Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж бататгах

Нэвтрэх үнэмлэхний хүчинтэй байдлыг ИНЕГ-ын өгөгдлийн сангаас баталгаажуулж болно. Мөн НАХҮБ нь энэ өгөгдлийн санд нэвтрэх бүрэн эрхтэй. Монгол Улсад олгосон бүх нисэх багийн үнэмлэхний тодорхойлолт нь ИНЕГ-ын өгөгдлийн санд тусгагдсан байна. Энэ систем нь дараах шаардлагыг бататгана:

- (a) олгосон үнэмлэхийг хурдан, зөв таньдаг байх;
- (b) гээгдүүлсэн / хулгайлагдсан нэвтрэх үнэмлэхийг нэн даруй хүчингүй болгодог байх;
- (c) нисэгчийн үнэмлэхний тодорхойлолтыг бататгадаг байх.

Нэвтрэх зорилгоор ашигладаг нэвтрэх үнэмлэх болон нисгэгчийн үнэмлэхийг шалгаж байгаа НАХ-ын ажилтан нь тухайн баримт бичгийн хүчинтэй байдалд эргэлзэж байгаа бол ИНЕГ-тай хамтран шалгаж бататгана. Хэрэв тухайн нэвтрэх үнэмлэх, эсхүл үнэмлэхийг нь гээгдүүлсэн, эсхүл хулгайлагдсаныг мэдэгдсэн, эсхүл бусад байдлаар хүчингүй болсон эсэхийг шалгаж тогтооно.

A.16. Аюулгүйн хамгаалалтын дагалдах үйлчилгээ

Аюулгүйн хамгаалалтын удирдлага нь агаарын хөлөг, агаарын хөлгийн үйл ажиллагаа, нисэхийн байгууламжийг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж, тэнд байгаа хүмүүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор аюулгүйн хамгаалалттай аэродромын аюулгүйн хамгаалалттай бүсүүдэд аюулгүйн хамгаалалтын дагалдах үйлчилгээгээр хангана.

НАХ-ын ажилтан нь хөдөлгөөний бүсэд тээврийн хэрэгсэл болон хүмүүсийг чадварлагаар аюулгүй дагуулж явна. НАХ-ын ажилтан дагалдах үйлчилгээг эхлэхээс өмнө тээврийн хэрэгслийн жолооч болон дагалдах этгээдэд товч мэдээлэл өгөх үүрэгтэй. Ингэхдээ дагуулж байгаа тээврийн хэрэгслийг байнга дагах тодорхой зааварчилгааг өгнө. Зааварчилгаанд дэмжлэг өгөх зорилгоор хэвлэж бэлтгэсэн материалыг ашиглаж болно.

Аюулгүйн хамгаалалттай бүсэд байх шаардлагатай боловч тэнд ихэвчлэн ажилладаггүй хүн болон тээврийн хэрэгсэл нь агаарын хөлөг, хүн, эсхүл төхөөрөмжид гэмтэл, эсхүл хохирол учруулахгүй байх, эсхүл агаарын хөлөгт зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэхэд дагалдах үйлчилгээний зорилго оршино.

Тухайн этгээд тус нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай, эсхүл үйл ажиллагааны бүсэд байгаа агаарын хөлгийн аюулгүй байдалд баталгаа өгч чадах хангалттай эрх мэдэл, эсхүл сургалтад хамрагдсан эсэхэд ямар нэг эргэлзээ байгаа тохиолдолд дагалдах үйлчилгээгээр хангана.

Ямар ч тохиолдолд аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх этгээд, эсхүл тээврийн хэрэгсэлд хангалттай нэвтрэх шалтгаан байх ёстой.

A.17. Явган эргүүл

Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаанд заналхийлж болзошгүй гэмт этгээдийг илрүүлэх болон аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл түүнтэй адилтгах газарт гарсан аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авахад явган эргүүлийн зорилго оршино.

Аюулгүйн хамгаалалтын зөрчил гарч болох аэродром орчмын эмзэг газруудад явган эргүүл хийнэ. Явган эргүүл нь тогтмол бус шинжтэй бөгөөд барилга, байгууламж, төхөөрөмжийг очиж шалгах цагууд өөр өөр байна.

НАХ-ын ажилтан нь зорчигч буруу замаар агаарын хөлөг рүү явах болон бусад аюултай нөхцөл байдалд орохоос сэргийлэхийн тулд сонор сэрэмжтэй байна. Агаарын хөлөг, терминалын хооронд зорчигчдод тавих агаарын тээвэрлэгчийн хяналт сул байгаагаас болж зөрчил гарсан тохиолдолд аюулаас зайлсхийх шуурхай арга хэмжээ авч, зөрчлийн талаар тайлан үйлдэх ба аюулгүйн хамгаалалтын удирдлагын нэгжээс агаарын тээвэрлэгчид мэдэгдэнэ.

A.18. Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт

НАХ-ын ажилтан нь нислэгт гаргахаар эцсийн шатны бэлтгэлд байгаа олон улсын бүх агаарын хөлөгт шууд анхаарал хандуулж ерөнхий хяналтдаа байлгах шаардлагатай.

Агаарын хөлгийн зогсоолд аюулгүйн хамгаалалтын эргүүл хийх нь зөвшөөрөлгүй хүн агаарын хөлөг рүү ойртох, зөвшөөрөгдөөгүй эд зүйл нэвтрүүлэхээс сэргийлэх зорилготой юм.

Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтыг хангах үндсэн үүргийг хүлээнэ. Агаарын хөлгийн шат, эсхүл хоолойг салгах, агаарын хөлгийн хаалгыг цоожилсон байх үүргийг агаарын тээвэрлэгч хариуцна.

Агаарын хөлгийн зогсоолыг гэрэлтүүлсэн байна. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн зогсоолыг гэрэлтүүлгээр хангах үүргийг хүлээнэ.

Агаарын хөлгийг хяналтгүй, хамгаалалтгүй орхисон, эсхүл шат/хоолойг салгаагүй тохиолдолд аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс зөвлөмж авах, тухайн асуудлыг шийдвэрлэхэд оролцох хүсэлт тавина.

Агаарын хөлгийг тойрч, нүдэн үзлэг хийхэд хүн, эсхүл зөвшөөрөгдөөгүй эд зүйлийг нуусан байж болзошгүй байрлалд анхаарал хандуулах зорилготой аюулгүйн хамгаалалтын эргүүлийн ажиллагаа багтана.

Өмнөх зүйлд заасан арга хэмжээнээс гадна, тухайн агаарын хөлөг хөндлөнгийн халдлагад өртсөн байж болох шалтгаан байгаа бол агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийг агаарын хөлөгт ирэхийг шаардана.

A.19. Эргүүлийн тээврийн хэрэгсэл

Эргүүлийн тээврийн хэрэгсэл нь үүрэг гүйцэтгэхэд шаардлага хангасан найдвартай ажиллагаатай байна.

Тээврийн хэрэгсэл нь бүх газруудтай холбогдох радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Түүнчлэн, тээврийн хэрэгслийг дохиоллын гэрэл, гар чийдэн, гэрэл тусгагч, гал унтраагчаар тоноглож, эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл байрлуулна.

A.20. Нууцлал болон мэдээлэл

“Мэдээ”-г аюулгүйн хамгаалалтын төлөвлөлтөд шууд ашиглахад боломжтой, эсхүл чухал ач холбогдолтой байж болох түүхий мэдээллийг албан дүгнэлт болгож хувиргахад чиглэгдсэн цуглуулах, үнэлэх, харьцуулах, задлан шинжлэх тасралтгүй цогц үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн гэж тодорхойлж болно.

“Мэдээлэл”-ийг эх сурвалж, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл, эсхүл бусад шалтгаанаар албан мэдээ боловсруулах үйл явцаар орж үнэлэгдээгүй болон үнэлэгдэх боломжгүй хэдий ч аюулгүйн хамгаалалтын төлөвлөлтөд авч хэлэлцүүлэх шаардлагатай албан ёсны, эсхүл албан бус эх сурвалжаас хүлээж авсан мэдээлэл гэж тодорхойлж болно.

НАХҮБ нь цагдаагийн байгууллага, ИНЕГ, Тагнуулын ерөнхий газар, агаарын тээвэрлэгчид, гадаадын холбогдох байгууллага болон бусад эх сурвалжаас мэдээ, эсхүл мэдээлэл хүлээн авч болно.

Мэдээ, эсхүл мэдээлэл нь ИНЕГ-аас өөр бусад байгууллагаас ирсэн тохиолдолд тухайн эх сурвалжаас үл хамааран даруй холбоо тогтоож магадлах шаардлагатай. Гэхдээ аюулгүйн хамгаалалтын ангиллаас нь хамаарч тухайн мэдээлэлд тааруулан хандана.

Мэдээллийг зөвхөн “мэдэгдэх шаардлагатай” гэсэн үндсэн дээр тохирох хувь хүн, эсхүл байгууллагуудад мэдэгдэж болох ба уг мэдээллийн ангиллыг харгалзан тухайн хүлээн авах эрхтэй хүмүүст л мэдэгдэж болно.

Мэдээллийг хүлээн авахаар зөвшөөрөгдсөн хувь хүн, эсхүл агентлагт зөвхөн “мэдэж байх шаардлагад” үндэслэн түгээнэ.

A.21. Бусад байгууллагатай харилцах

Нөөц төлөвлөгөөнд эмзэг цэгүүдийн хамгаалалтад зориулж, эсхүл хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас хамгаалах, эсхүл бусад онцгой нөхцөл байдлыг дэмжих нөөц үйлчилгээ, хангамжийг урьдчилан бэлтгэсэн байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулахдаа, нөөц төлөвлөгөөнд оролцох аюулгүйн хамгаалалтын удирдлага нь нисэх буудал дээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллагуудтай зөвшилцөх болон хамтран ажиллах нь чухал.

Албан ёсны хамтын ажиллагааг нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороо, эсхүл онцгой байдлын дэд хороогоор дамжуулан тогтоож болно.

НАХҮБ-ын удирдлагын нэгж нь бусад байгууллагын бүх ажилтны аюулгүйн хамгаалалтын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хариу мэдээлэл авах хангалттай мэдээлэл өгөгдөж байгааг бататгах үүрэгтэй.

A.22. НАХ-ын ажилтны эрүүл мэндийн шаардлага

НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь эмнэлгийн үзлэгт НАХ-ын ажилтны ажлын байранд хүсэлт гаргагч бүр тухайн ажлын байрны үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд тохирч байгаад үнэлгээ хийгдсэн болохыг бататгана.

Тухайн заалтад нийцүүлэх зорилгоор, эрүүл мэндийн ерөнхий үзлэгт үндэслэн НАХ-ын ажилтан нь ажил, үүрэг гүйцэтгэхэд тохирч байгаад үнэлгээ хийхэд тавих шаардлагыг журамд нарийвчлан тусгах шаардлагатай.

Гэрчилгээ эзэмшигч нь хүсэлт гаргагчийг /шаардлагатай тохиолдолд ажилтныг/ үзлэгт хамруулж шалгах зорилгоор ИНЕГ-ын томилогдсон эрүүл мэндийн шалгагч болон эрүүл мэндийн зөвлөх эмч нарыг сонгох эрхтэй бөгөөд тэд өөрсдийн хэрэглэдэг маягт, баримт бичгээ ашиглахыг зөвшөөрдөг.

ИНД-67-гийн дагуу нислэгийн хөдөлгөөний удирдагч нарт тавьдаг эрүүл мэндийн үзлэг, үнэлгээний системд үндэслэх нь шаардлага хангасан гэж үзнэ.

Эрүүл мэндийн үзлэгийн маягт нь ИНД-67.107-д заасан эрүүл мэндийн 3-р ангиллын стандартад шаардсан нөхцөлөөс гадна дараах нөхцөл багтаана.

(а) 3-р ангиллын шаардлагаас ялгаатай шаардлагууд:

- (i) **АМЬСГАЛ, ЗҮРХ СУДАСНЫ СИСТЕМ:** НАХ-ын ажилтны ажил нь суугаа ажил биш тул цагдаа болон гал түймэртэй тэмцэх ажилтнуудад тавьдаг бие бялдрын ижил шаардлага тавьдаг. Хэт тарган байж болохгүй (биеийн таргын 20 хувиас хэтрэхгүй) ба зүрх судас, амьсгал болон яс булчингийн системийн эмгэг өвчнийг оношилсон байна;
- (ii) **ЭМ:** Дасгал сургуулилт гүйцэтгэх үед бета хоригийн эмийн хэрэглээ нь эсрэг заалттай байдаг. Цусны даралт ихсэх гэх мэт өвчний үед тогтмол эм хэрэглэх нь хүсэлт гаргагчийн хувьд ажил үүрэг гүйцэтгэхэд эрсдэлтэй эсэхийг эхний шатанд шалгасан байна;
- (iii) **ХОЛЫН ХАРАА:** Хүсэлт гаргагчийн холын хараа нь нүд тус бүр 6/12-оос доошгүй байна.
 - Хүсэлт гаргагчийн хараа нь 6/36 хэмжээнд хүрэхгүй бол холын харааны шил зүүнэ.
 - Мөн хүсэлт гаргагчийн хараа 6/36 хэмжээнд хүрэхгүй бол холын харааг засах зорилгоор контакт линз зүүхийг зөвшөөрнө.
- (iv) **ОЙРЫН ХАРАА:** Хүсэлт гаргагч нь N5-ын дүрсийг 33 см-ийн зайнаас, N14-ийн дүрсийг 100 см-ийн харж унших чадвартай байна. Нүдний шил хэрэглэсэн нөхцөлд дээрх стандартыг хангасан этгээдэд гэрчилгээ олгож болно;
- (v) **ӨНГӨ ЯЛГАХ ЧАДВАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА:** 3-р ангиллын эрүүл мэндийн гэрчилгээнд тавигдах шаардлагатай адил, боловч шалтгаан нь өөр байдаг. Хүсэлт гаргагчийн өнгө ялгах чадвар хэвийн байх шаардлага тавьдаг;
- (vi) **СОНСГОЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:** Сонсголын хэрэгсэл хэрэглэхийг зөвшөөрдөггүй. Аудиограм нь үнэлгээний стандартын нэг хэсэг биш боловч нисэхийн орчны чимээний улмаас ажилд орохын өмнө шалгуулсан байх шаардлагатай;
- (vii) Үнэрлэх чадвар хэвийн байх шаардлагатай. Ер нь ИНЕГ-ын ЭМГ авахад шалгадаггүй ч шалгагч сорилын 3 саваар шалгах нь зүйтэй.
- (viii) Үзлэгийн маягт дээр ямар нэгэн хязгаарлалт болон дуусах он сар өдрийг заахыг хориглоно. Гэхдээ байгууллагад шаардлагатай мэдээлэл (эрүүл мэндтэй холбоотой нууц мэдээ биш бол)-ийг бичсэн байх шаардлагатай.

НАХ-ын ажилтан ажил эрхэлж байх хугацаандаа эрүүл мэндийн эдгээр стандартуудыг хангаж байх бололцоот баталгааг олгосон журамтай байхыг НАХҮБ-ын гэрчилгээ эзэмшигчид зөвлөмж болгосон байдаг.

А.24. Давтан сорилт хийх

Дахин сорилт хийх гэрчилгээ эзэмшигч, аюулгүйн үзлэгийн үүрэг гүйцэтгэж байгаа бүх ажилтан нь металл илрүүлэлт, рентген төхөөрөмжийн дэлгэц дээр дүрс таних, өнгө ялгах, зорчигчийн биед болон тээшинд гараар үзлэг хийх зэрэг өөр өөр ажил үүргийг гүйцэтгэх болон үзлэгийн дараах бүсийн болон агаарын хөлгийн шалгалт хийх мэргэшлийн чадвартай болохыг бататгана.

Сорилтыг, аюулгүйн үзлэгийн үйл ажиллагааны бүрэн бүтэн байдалд үнэлгээ өгөх зорилгоор хийх ба тухайн сорилтод орж байгаа ажилтанд сорилын биетийг илрүүлэх боломжийг олгох хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

Тухайн сорилт нь энгийн зорчигчийн авч яваа ердийн тээшинд байх эд зүйлээс сорилын биетийг илрүүлэх боломжийг олгодог байх ёстой.

Шалгалтын журам - Сорилын тээгчийг энгийн хэлбэрээр, эсхүл тээврийн хэрэгсэлд суусан, эсхүл ачигдсан байдлаар нэвтрүүлдэг байна (хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэр болон хүүхдийн тэрэг г.м). Стандарт сорилын биетийг тээгчид нуух, эсхүл ямар нэг зөөвөрлөх хэрэгсэлд байрлуулж нууна.

Хэрэв металл илрүүлэгч хаалганы дохиолол байхгүй, ямар нэгэн шалтгаанаар ашиглахгүй байгаа бол, тухайн шалгагч нь НАХ-ын ажилтныг гар-металл илрүүлэгч ашиглан, эсхүл биед нь шалгалт хийн сорилын биетийг таньж илрүүлж байгаа эсэхийг тогтооно.

Сорилт хийж байгаа шалгагч стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж байгаа бусад эд зүйлийн дунд санамсаргүй байдлаар байрлуулна. Стандарт сорилын биетийг гар тээшинд, эсхүл туузан дамжуурга дээр тусад нь татвараас чөлөөлөгдсөн бараа, цаас, номын хамт байрлуулж болно. Мөн шалгагч стандарт сорилын биетийг гараар зайлшгүй шалгах шаардлагатай зургийн аппарат, дүрс бичлэгийн хэрэгсэл, зургийн хальсны саванд байрлуулж болно.

Сорилтод орж байгаа ажилтан стандарт сорилын биетийг рентген төхөөрөмжийн дэлгэц дээр дүрс, эсхүл өнгөөр нь зөв таньж, дараагийн гар шалгалтын үед байрлуулж чадаж байгаа эсэхийг шалгагч тогтооно.

Овор хэмжээ/өнгө/төөрөгдлийн улмаас тээшний агууламж нь зөв танигдахгүй байгаа үед НАХ-ын ажилтан нь гар шалгалт хийх хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох шийдвэр гаргах чадварт үнэлгээ хийх ажиллагааг тухайн сорилт нь багтаана.

Биед хийх шалгалт - Биед хийх шалгалтад оролцдог аюулгүйн хамгаалалтын бүх ажилтан гар болон бүртгэсэн тээшинд энэхүү шалгалтад хамрагдсан байх шаардлагатай. Сорилт хийж байгаа шалгагч стандарт сорилын биетийг аюулгүйн үзлэг хийгдэж байгаа бусад эд зүйлийн хамт санамсаргүй байдлаар байрлуулна. Стандартын сорилын биетийг цүнхийг нээх үед нүдэнд ил харагдахаар байрлуулж болохгүй. Стандарт сорилын биетийг биед хийх шалгалтын тогтсон журмын дагуу илрүүлнэ.

Гараар шалгах хүсэлт гаргах - Сорилыг авч яваа сорилын тээгч ажил үүргээ гүйцэтгэж байгаа НАХ-ын ажилтнаас нууцалсан эд зүйл бүхий өөрийн гар тээшээ гараар биечлэн шалгах хүсэлт тавина. Энэ бол зөвшөөрөгдсөн журам юм. Стандарт сорилын биетийг тухайн цүнх, савыг нээх үед нүдэнд ил харагдахаар байрлуулж болохгүй. Стандарт сорилын биетийг гараар шалгалт хийх тогтсон журмын дагуу олж илрүүлнэ.

Үзлэгийн дараах бүсийн шалгалт - Үзлэгийн дараах бүсийг шалгах ажиллагаанд оролцож байгаа бүх ажилтан сорилтод хамрагдсан байна. Сорил хийж байгаа шалгагч шалгалтаас өмнө нисэн гарч байгаа зорчигч авах боломжтой үзлэгийн дараах бүсэд стандарт сорилын биетийг байрлуулна. Стандарт сорилын биетийг байрлуулах газар нь зөвхөн аюулгүйн үзлэгийн цэгээс зорчигч агаарын хөлөгт хүрэх

хүртэлх бүсээр хязгаарлагдана. Сорилд хамрагдаж байгаа НАХ-ын ажилтан үзлэгийн дараах бүсийг шалгах явцад нуусан эд зүйлийг илрүүлж чадаж байгаа эсэхийг шалгагч тогтооно.

Агаарын хөлгийн шалгалт - Агаарын хөлгийг шалгах ажиллагаанд оролцож байгаа бүх ажилтан сорилд хамрагдсан байна. Шалгагч стандарт сорилын биетийг шалгалтад орох агаарын хөлгийн аль нэг хэсэгт байрлуулна. Зорчигч чөлөөтэй нэвтэрдэг агаарын хөлгийн хэсэгт нуусан байна. НАХ-ын ажилтан агаарын хөлгийг шалгах явцад нуусан сорилын биетийг илрүүлж чадаж байгаа эсэхийг шалгагч тогтооно.

Стандарт сорилын биет - Сорилт хийх зорилготой учраас бүх сорилын биет нь бодит зүйлийг онолын хувьд илэрхийлэх бөгөөд ингэснээр амь нас, эд хөрөнгөд бодит аюул учруулж байгаа биетийг төлөөлнө.

Нэгээс дээш сорилын биетийг аливаа эд зүйлд байрлуулах нь үзлэг шалгалт хийх ур чадварын түвшнийг шалгах нийтлэг жишиг юм.

Сорилт болон давтан сорилт хийх зорилгоор, төрөл бүрийн стандарт сорилын биетийг тодорхой хугацааны давтамжтай ашиглана. Аюулгүйн үзлэгийн үүрэг гүйцэтгэдэг бүх хүмүүст сорил хийнэ. Стандарт сорилын биетийг илрүүлэхэд гаргасан амжилтын, эсхүл алдааны түвшнийг тухайн ажилтны болон баг хамт олны ур чадварыг хэмжихэд ашиглана. Энэхүү хэмжүүр нь стандартуудыг хангаж байгаа эсэх, эсхүл стандартад хүрэхэд дараагийн шатны ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлно.

НАХҮБ-ын удирдлагын зүгээс сорилоо амжилтгүй өгсөн хүмүүсийг залруулах сургалтад хамруулж, дараа нь тэдэнд сорилтод унасан тухайн үүрэгт ажилдаа буцаж орох зөвшөөрөл өгөхөөс өмнө стандартыг хангаж байгааг батлахын тулд дахин сорилтод хамруулах үүрэгтэй.

Залруулах сургалтын дэлгэрэнгүй мэдээл болон сорилын үр дүнгийн талаар аудит хийх зорилгоор бүртгэл хөтөлнө.

Бодит нислэгийн үед сорилтод хангалтгүй үнэлгээ үзүүлсэн тохиолдолд тухайн баримтыг НАХҮБ-ын үйлдвэрлэлийн нэгж, удирдлагад мэдэгдэнэ. НАХҮБ-ын удирдлага болон тухайн агаарын тээвэрлэгчийн холбогдох хүмүүс зөвшилцсөний үндсэн дээр зорчигч, үзлэгийн дараах бүс болон агаарын хөлөгт хийх шалгалтыг туршлагатай хүмүүсээр дахин гүйцэтгүүлнэ.

НАХ-ын ажилтан сорилтод хангалтгүй үнэлгээ үзүүлж, шаардлагатай стандартыг хангаагүй тохиолдолд аюулгүйн хамгаалалтын үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

Сорил тээгч - Тухайн сорилын шинж чанар болон сорилын хийц загварын талаар сорил тээгчид хэлж болохгүй. Сорилын биетийг илрүүлээгүй гэдэг нь тээгчид тодорхой болбол шалгагч аюулгүйн үзлэгийн цэгийн цаанаас сорилыг авна. Хэрэв аюулгүйн үзлэгийн ажилтан тээгчийг, эсхүл стандарт сорилын биетийг агуулсан цүнхийг гараар шалгах шаардлагатай гэж үзвэл тээгч нь шаардсаны дагуу дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

Хуваарьт нислэгийг саатуулахаар бол давтан сорилыг хийхгүй байж болно.